



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/162

Улаанбаатар хот

“Ажлын байрны ашиглалтын зааварчилгаа” батлах тухай



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажлын байрны онцлогт нийцсэн “Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа”-г 1 дүгээр хавсралтаар, “Өргөх төхөөрөмж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 2 дугаар хавсралтаар, “Оффисын ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 3 дугаар хавсралтаар, “Гар цахилгаан багаж ашиглан гүйцэтгэх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 4 дүгээр хавсралтаар, “Гагнуурчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 5 дугаар хавсралтаар, “Слесарийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 6 дугаар хавсралтаар, “Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 7 дугаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Үйлдвэрлэлийн албаны дарга, Ерөнхий инженер, Ерөнхий механик, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэгт тус тус үүрэг болгосугай.
3. Зааварчилгааны хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүй, аудитын алба /Л.Батбаяр/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




М.ГАНБААТАР

	Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-АА-01	
		Хувилбар: 1	
		Тушаал № А/162	

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	<i>[Signature]</i>	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	<i>[Signature]</i>	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

	Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-АА-01	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 онсар өдөр
		Тушаал №	

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-АА-01
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-АА-01
	Хувилбар: 1

Агуулга

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага	4
Хоёр. Үйлдвэрийн бүсэд ажилд гарах, ажлаас буух ажилтны аюулгүй зорчих зааварчилгаа	5
Гурав. Цахилгааны аюулгүй байдлыг хангах	6

Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-АА-01
	Хувилбар: 1

НЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ

АХУЙН ШААРДЛАГА

- 1.1. Ажилтан эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдсан байх.
- 1.2. Хөдөлмөрийн хүнд, хортой, аюултай нөхцөлд ажилладаг ажилтан эрүүл мэндийн хугацаат үзлэгт тогтмол хамрагдсан байх. Ажлын байрны хөдөлмөрийн хүнд, хортой, аюултай нөхцөлд 18 нас хүрээгүй иргэнээр ажил гүйцэтгүүлэхийг хориглоно.
- 1.3. Тухайн ажлын байранд шаардлагатай хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэх, бичиг баримтгүй ажилтнаар ажил гүйцэтгүүлэхийг хориглоно.
- 1.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шинээр ажилд орж байгаа иргэний сургалтанд хамрагдаж мэдлэг сорих шалгалт өгч тэнцсэн, ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа авч шалгалт өгч тэнцсэн ажилтнаар туршлагатай бие даан ажил гүйцэтгэх зөвшөөрөлтэй ажилтныг дагалдуулж ажил гүйцэтгүүлнэ.
- 1.5. Ажлын байранд 3 хүртэл сарын хугацаанд дадлагажиж, шалгалт өгч тэнцсэн ажилтныг инженер техникийн ажилтны зөвшөөрлөөр бие даан ажил гүйцэтгэхийг зөвшөөрнө.
- 1.6. Ажилтан нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, түүний бүрэлдэхүүн, хөдөлгөөнт эд анги, хэсгийн бүтэц, ажиллагааг бүрэн мэддэг байх.
- 1.7. Ажилтан нь технологийн процесс болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандарт норм, дүрэм журам, заавар зааварчилгаа өөрчлөгдсөн, үйлдвэрийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл өөрчлөгдсөн, шинэчлэлт, сайжруулалт хийгдсэн, хөдөлмөрийн нөхцөл, зохион байгуулалт өөрчлөгдсөн, календарын 30 ба түүнээс дээш хоногоор (хөдөлмөрийн хүнд, хортой, аюултай нөхцөлд ажилладаг ажилтан 15 ба түүнээс дээш хоногоор) ажил завсарласан зэрэг тохиолдолд шууд харъяалах албан тушаалтнаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ээлжит бус давтан зааварчилгаа авсан байх.
- 1.8. Ажилтан зөвхөн өөрийн ажлын байрны тодорхойлолтонд тусгагдсан чиг үүрэг болон шууд харъяалах албан тушаалтнаас өөрт даалгасан үүрэг даалгаврыг гүйцэтгэх үүрэгтэй.
- 1.9. Ажлыг аюулгүй гүйцэтгэхэд асуудал гарвал шууд удирдлагадаа мэдээлэх үүрэгтэй.
- 1.10. Ажилтан компанийн хөдөлмөрийн дотоод журам, ажлын байранд дагаж мөрдөх хууль тогтоомж, стандарт норм, дүрэм журмуудтай танилцах, дагаж мөрдөх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах заавар зааварчилгааг биелүүлэх, хамтын болон хувийн хамгаалах хэрэгслийг бүрэн гүйцэд, зөв хэрэглэх үүрэгтэй.

Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-АА-01
	Хувилбар: 1

- 1.11. Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл нь ажлын нөхцөл, онцлог, агуулгад нийцсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага стандарт хангасан, чанарын сертификаттай байна. Техникийн баримт бичиггүй, туршилт шалгалтанд орж тэнцээгүй болон эвдрэл, гэмтэлтэй хувийн хамгаалах хэрэгслийг ажилтнуудад олгох, хэрэглэхийг хориглоно.
- 1.12. Ажилтан олгож өгсөн ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг ажил гүйцэтгэхдээ хэрэглэх үүрэгтэй бөгөөд тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг бүрэн хариуцна. Ашиглах хугацаа хэтэрсэн хамгаалах хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.
- 1.13. Тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бүрэн бүтэн, хэвийн ажиллагаатай, ашиглах зөвшөөрөлтэй багаж хэрэгсэл, материалаар бүрэн хангагдсан байх.
- 1.14. Багаж хэрэгсэл, материалыг зориулалтын дагуу ашиглах бөгөөд бүрэн бус, хэвийн ажиллагаа алдагдсан, зөвшөөрөлгүй багаж хэрэгсэл, ашиглахыг хориглоно.
- 1.15. Үйлдвэрийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн хийц, зориулалт, үйлдвэрлэлийн технологийн горим, орц найрлагийг дур мэдэн өөрчлөхийг хориглоно.
- 1.16. Ажилтан өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд эрсдэл учруулах, компанийн нэр хүнд, үйлдвэрийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, компанийн эд хөрөнгө эвдэх, гэмтээх, байгаль орчинд хохирол учруулах үйлдэл хийхийг хориглоно.
- 1.17. Ажилтан бусад ажилтны аюулгүй ажиллагаа зөрчигдөж байгаа тохиолдолд бусдад анхааруулах болон аюулыг арилгах арга хэмжээг авч, шууд удирдлагадаа мэдээлэх үүрэгтэй.
- 1.18. Эмнэлэгийн анхан шатны тусламжийн хэрэгсэл, гал унтраах анхан шатны багаж зэвсэглэл ашиглах мэдлэг, чадвар болон барилга байгууламжийн гол ба туслах гарц, осол аваари, гамшгийн үед нүүлгэн шилжүүлэлтийн гарц зэргийн байршлыг мэддэг байх.
- 1.19. Осол гэмтлийн үед хохирогчид (өөрт болон бусдад) анхан шатны тусламж үзүүлж чаддаг байх үүрэгтэй.

ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН БҮСЭД АЖИЛД ГАРАХ, АЖЛААС БУУХ АЖИЛТНЫ АЮУЛГҮЙ ЗОРЧИХ ЗААВАРЧИЛГА

- 2.1. Явган хүний зориулалтын замаар зорчих ба замгүй тохиолдолд хөдөлгөөн хийж байгаа тээврийн хэрэгслийн өөдөөс угтах чиглэлийн зүүн гар талыг баримтлан явна. (Өөрийн баруун гар талыг барь явна)
- 2.2. Тээврийн хэрэгсэл ойртон ирэхэд жолоочийн өгөх сигналыг хүлээлгүй хөдөлж байгаа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгөх ба зам хөндлөн гарахдаа тогтоосон газраар хоёр талаас тээврийн хэрэгсэл байхгүйг нягталсны дараа яаралгүй гарна.
- 2.3. Төмөр замыг хөндлөн гарахдаа рельсийн толгой дээр зогсохыг хориглоно.

Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-АА-01
	Хувилбар: 1

- 2.4. Хөдөлгөөнөө бүрэн зогсоогоогүй тээврийн хэрэгсэлд суух, буухыг хориглоно.
- 2.5. Хүн тээврийн зориулалтын бус тээврийн хэрэгслээр зорчих, хүн тээвэрлэхийг хориглоно.
- 2.6. Тээврийн хэрэгслийн бүхээгээс үсэрч буухыг хориглоно. Зориулалтын шат, тусгай хаалтаар болгоомжтой 3 цэгийн зарчмыг баримтлан бууна.
- 2.7. Ямагт аюулгүй зам талбай сонгон зорчих. Зам товчлох зорилгоор хангалттай гэрэлтүүлэггүй харанхуй газар, тоног төхөөрөмжийн дээгүүр болон доогуур зорчихыг хориглоно.
- 2.8. Дараах ажил гүйцэтгэж байгаа өндөр эрсдэлтэй ажлын байр, ажилбаруудын аюултай бүсэд нэвтрэхийг хориглоно.
- ❖ Өндрийн ажил (газрын төвшнөөс 1.3 метрээс дээш өндөрт болон газрын төвшнөөс доош 1.3 метрээс илүү гүнтэй худаг, цооног, ухсан нүхэнд орж, тэдгээрийн ирмэгийн ойролцоо гүйцэтгэх ажил);
 - ❖ Гар багажаар гүйцэтгэх ажил (бүх төрлийн цахилгаан багаж, газар шорооны, цахилгааны, цохих, давтах, хусах, зүлгэх, цоолох, гагнах г.м.);
 - ❖ Өргөх зөөх ажиллагаа (сэрээт өргөгч, дугуйт ачигч, автокран, манипуляторт кран зэрэг хөдөлгөөнт техник ба гар болон цахилгаан таль, домкрат зэрэг багаж хэрэгсэл ашиглан ачаа өргөх, ачааг гараар өргөх зөөх, ачих буулгах);
 - ❖ Хөдөлгөөнт техник хэрэгсэл ашиглан гүйцэтгэх ажил;
 - ❖ Өндөр хэмийн ажил (бүх төрлийн гагнуур, ил галтай, зуух галлагаа, хөрөөдөх, таслах, огтлох г.м.);
 - ❖ Эргэлдэх механизм (туузан дамжуулга, араан дамжуулга г.м.);
- Зайлшгүй тохиолдол дээрх ажил гүйцэтгэх талбай, аюултай бүсээр зорчих үедээ аюулгүй байдлаа бүрэн хангасан байх. (дээрээс эд зүйл унахаас, төмрийн үрдэс, хатуу биет бие, эд эрхтэн, хувцас хэрэгсэлд зоогдох, шигдэх, хатуу биетэд цохиулах, хавчуулагдах, мөргүүлэх, халуун биетэд түлэгдэх, шатах, эргэлдэх механизмд хавчуулагдах, орооцолдох, бүдрэх, халтирах, унах зэрэг аюулаас сэрэмжлэх)
- 2.9. Үйлдвэрийн бүсэд архи согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх, тайвшруулах үйлчилгээтэй болон хууль бус эм бэлдмэл хэрэглэхийг, дээрх зүйлсийг хэрэглэсэн үед үйлдвэрийн бүсэд нэвтрэхийг хориглоно.

Үйлдвэрийн бүсэд зөвхөн зөвшөөрөгдсөн цэгт тамхи татна.

ГУРАВ. ЦАХИЛГААНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

- 3.1. Шалбархай утас, цахилгааны хуваарилах самбар, цахилгаан тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн метал эд ангид нүцгэн гар, биеийн бусад хэсгээр хүрэхийг хориглоно.

Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа	ТТТ-АА-01
	Хувилбар: 1

- 3.2. Унасан, тасарсан цахилгаан гүйдэл дамжуулах шугам, газардуулга, утсыг өргөх, түүн дээр зогсохыг хориглоно.
- 3.3. Цахилгаан багаж хэрэгслийг хүчдэлээс салгалгүй орхиж явахыг хориглоно.